



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 18/30

Улаанбаатар хот

Г Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 11 дүгээр тогтоол, Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/128 дугаар тушаалаар баталсан "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр" (2017-2020 он)-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/160, А/161 дугаар тушаалын хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор ТУШААХ нь:

1. "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийг 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн заавар, Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг үндэсний түвшинд сурталчилах, судлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцож ажиллахыг Мэргэжлийн тусламжийн алба /Д.Ганболд/, Мэргэжлийн багийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын алба /Э.Тунгалаг/-нд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

МОНГОЛЫН
СЭХҮЭГ
ХАМГААЛАХ
ТӨСӨӨ

0000078

Төвийн захирлын 2014 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 430 дугаар тушаалын хавсралт

“ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдал уян хатан, чанартай, хүртээмжтэй, шуурхай зохион байгуулах чадавхи, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулахад оршино.

№	Үйл ажиллагаа	№	ХӨСХҮХ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүн	Тайлант онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх байгууллаганэгж
Зорилт 3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, цартахал, томуу, томуу тест өвчний тандалтыг өргөжүүлэх замаар хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган, орчны бохирдолтой холбоотой халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх, тандах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
Үйл ажиллагааны чиглэл 1. ДЭМБ-ын Ази, Номхон далайн баруун бүсийн “Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвартай тэмцэх стратеги (III)”-ийн бодлого, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын тандалт, хяналт, хариу арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
3.3.1.1	Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг нэмэгдүүлж, салбар дундын болон салбар хоорондын үйл ажиллагааны эрхзүйн орчныг боловсронгуй болгон үйл ажиллагааг уялдуулах	1	Халдварт өвчний тандалтын мэдээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох	Халдварт өвчний тандалтын мэдээ, мэдээллийн нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	II улиралд	Батлагдсан баримт бичиг	ЗУББТСТ ШУН	ХӨСҮТ
		2	Халдварт өвчний 2030 он хүртэлх төлөвийг гаргах	Зоонозын халдварт өвчний 2030 он хүртэлх төлөвийг гаргана.	Жилдээ	Тооцооллын эмхтгэл	ЗУББТСТ	ЗТХНСА

3.3.1.2	Эрүүл мэндийн байгууллагад шуурхай удирдлагын нэгжийг үе шаттайгаар байгуулан мэдээлэл солилцоог тогтмолжуулах, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	1	“Шуурхай удирдлагын төв, нэгжийн үйл ажиллагааны нийтлэг журам”, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээний аргачлал боловсруулах	“Шуурхай удирдлагын төв, нэгжийн үйл ажиллагааны нийтлэг журам”, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээний аргачлал боловсруулах ажлын хэсэгт ажиллана.	Жилдээ	Батлагдсан журам	ЭУББТСТ ШУН	-
		3	Салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ авах журам /2017-2020/	Салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ авах журам боловсруулна.	Жилдээ	Батлагдсан журам	ЭУББТСТ ШУН	-
3.3.1.3.	Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед эрсдлийн үнэлгээ хийх болон халдварт өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулах, чанаржуулах, мэргэжилтнүүдийг давтан сургах	1	Тохиолдлын удирдлагын тогтолцооны талаар салбарын болон салбар хоорондын байгууллагын ажилтнуудад дасгал сургууллт хийх	Салбар хоорондын хамтарсан багаар ширээний болон, үзүүлэх сургуульд оролцох	Жилдээ	Дасгал сургуулалтын тоо	ЭУББТСТ ШУН	ЛЛТ
		2	Үйл явдлыг үнэлэх, баталгаажуулах, эрсдлийн үнэлгээний талаар ширээний дасгал сургууллт хийх	Үйл явдлыг үнэлэх, баталгаажуулах, эрсдлийн үнэлгээний талаар ширээний дасгал сургууль хийх, үндэсний хэмжээний сургуульд оролцоно.	Жилдээ	Дасгал сургуулалтын тоо	ЭУББТСТ ЛЛТ ШУН	ЭМЯ ШУТ

3.3.1.4.	Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний эрсдлийн нөөцийн санг (санхүүгийн болон эм, урвалж, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж г.м) бий болгож, жил бүр нөхөн хангалт хийх	1	ЗӨСҮТ дэх “Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөц”-д үнэлгээ хийх, шийдвэр гаргах	Дэд ажлын хэсэг байгуулж үнэлгээний бэлтгэл ажлыг хангана.	Жилдээ	Үнэлгээний тайлан	ЭУББТСТ	-
		2	Эрсдлийн нөөцийн санг бий болгох талаар Ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах	ХӨДББН-ийн танилцуулгыг ЭМЯ-нд хүргүүлж, жагсаалт шинэчилэх, нөхөн хангалтыг шийдвэрлүүлнэ.	III улиралд	Нөхөн хангалтын төрөл, тоо хэмжээ	ЭУББТСТ	-
Үйл ажиллагааны чиглэл 4. Халдварт өвчний лабораторийн оношилгоо, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
3.3.4.1	Биоаюулгүй ажиллагааны 3-р зэрэглэлийн лаборатори шинээр байгуулах, үйл ажиллагаа явуулж байгаа лабораториудад биоаюулгүй ажиллагаа, биохамгааллын эрсдлийн үнэлгээ хийж, түүний үр дүнд суурилсан төлөвлөлт хийх	1	Биоаюулгүй ажиллагааны талаар эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах	Биоаюулгүй ажиллагааны талаар багц цагийн сургалт зохион байгуулна	II улиралд	Сургалтад хамрагдсан хүний тоо	ЛЛТасаг	НЭМЭША
3.3.4.2	Лабораторийн шинжилгээний чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх	1	Олон улсын чанарын гадаад хяналтын хөтөлбөрт хамрагдах	Олон улсын чанарын гадаад хяналтад хамрагдана.	Жилдээ	Хамрагдсан лабораторийн тоо	ЛЛТасаг	-

3.3.4.3	Халдварт өвчний лабораторийн сүлжээ байгуулж, оношилгооны дэвшилтэт арга, технологийн шинэчлэлийг тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэх	2		Микробиологийн тэжээлт орчин хуурайшуулах тоосруулан хатаах тоног төхөөрөмжийн судалгааг хийнэ. 2018 оны төсвийн төлөвлөгөөнд тусгана.	Жилдээ	Тоног төхөөрөмжийн тоо	АХБУТасаг	-
		3	Орчин үеийн оношилгооны технологи нэвтрүүлж, оношлуур, урвалж, тоног төхөөрөмжөөр хангах	Хайхардаггүй зарим зоонозын өвчний лабораторийн оношилгооны технологийг нэвтрүүлэхээр турших, оношлуур, урвалжийг захиалах, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт гаргана.	Жилдээ	Тоног төхөөрөмж, оношлуурын тоо	ЛЛТасаг	-
		4	Нянгийн тэсвэржилтийн судалгаа хийх	Зоонозын өвчний үүсгэгчийн нянгийн тэсвэржилтийн судалгааны удирдамж боловсруулна.	Жилдээ	Судалгааны дүн	ЛЛТ	Орон нутгийн ЗӨСТөв
		5	Антибиотикт тэсвэржилтийн лабораторийн тандалтын тогтолцоог өргөжүүлэн сүлжээнд хамруулах	Зоонозын өвчний үүсгэгчийн антибиотикт тэсвэржилтийн судалгааны дүнг нэгтгэн, сүлжээнд хамруулна.	Жилдээ	Сүлжээнд хамрагдсан лабораторийн тоо	ЛЛТ	Орон нутгийн ЗӨСТөв

3.3.4.4	Халдварт өвчний лабораторийн сүлжээ байгуулж, оношилгооны дэвшилтэт арга, технологийн шинэчлэлийг тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэх	1	Инженерүүдийг орчин үеийн тоног төхөөрөмжийг засварлах сургалтад хамруулах.	Тоног төхөөрөмжийн засварлах богино хугацааны сургалтад хамрагдана.	Жилдээ	Сургалтын тоо	ЧХУДАА	-
		2	Лабораторийн тоног төхөөрөмжийн нэгдсэн тооллогыг жил бүр хийж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	Лабораторийн тоног төхөөрөмжийн тооллогыг хийж, шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлыг 2018 оны улсын төсөвт суулгана.	Жилдээ	Санхүүжилтийн дүн	СЭЗХҮА ЧХУДАА	ЛЛТ
3.3.4.6.	Лабораторийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	1	Лабораторийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	Үндэсний төвийн болон орон нутгийн ЗӨСТ-ийн лабораторийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэшил дээшлүүлэх болон дагалдан ургалтад хамруулах	Жилдээ	Оролцсон мэргэжилтний тоо	НЭМЭШСА	ЛЛТ
Зорилт 6. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих, зоонозын анзаарагддаггүй зарим өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний чадавхийг сайжруулна.								
Үйл ажиллагааны чиглэл 1. Зоонозын өвчний байгалийн голомтын тандалтын тогтолцоог бэхжүүлэх, идэвхжлийн зэргийг тогтоох, хяналтыг тогтмолжуулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
3.6.1.1	Нутагшмал, шинээр болон сэргэн тархаж байгаа зоонозын өвчний байгалийн голомтыг илрүүлэх, тандах, хянах	1	Нутагшмал болон шинээр сэргэж буй зоонозын халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны аргачлалыг батлуулах	Голомт хяналтын зааврыг шинэчлэх	2-р улиралд	Батлагдсан аргачлал	ЗӨСҮТ ЭУБТСТ	
		2	Зоонозын өвчний байгалийн	Тэргүүлэх чиглэлийн болон	Жилдээ	Тандалтын тайлан	ЗӨСҮТ	ЗӨСТ

			голомт болон хүн амын дунд эрт илрүүлэг, тандалт хийх	анзаарагддаггүй халдварыг хүн амын дунд илрүүлэх судалгааг нийслэл хот, орон нутагт хийх			ЭУББТСТ	
		3	Хил дамнасан бүс нутагт зоонозын өвчний хамтарсан тандалт судалгаа хийх, мэдээлэл солилцох тогтолцоо бий болгох	Монгол улсын баруун бүс Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Улаан хус сумын нутагт тарваган тахал хам тохиолдох өвчний тандалт хийнэ.	III улиралд	Тандалтын тайлан, Гэрээний биелэлт	ЭУББТСТ ЛЛТ	ОХУ
		4	Хил дамнасан бүс нутагт зоонозын өвчний хамтарсан тандалт судалгаа хийх, мэдээлэл солилцох тогтолцоо бий болгох	Дорнод аймгийн Чойбалсан сумын БНХАУ-тай хил залгаа орших боомт орчмын нутаг дэвсгэрт тарваган тахал болон түүнтэй хам тохиолдох өвчний тандалт хийнэ.	III улиралд	Тандалтын тайлан, Гэрээний биелэлт	ЭУББТСТ ЛЛТ	БНХАУ
		5	Байгалийн голомтын тандалт судалгааны үр дүнгийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох	Байгалийн голомтын тандалт судалгааны үр дүнгийн нэгдсэн мэдээллийн сан бий болгоно.	Жилдээ	Мэдээний сан	ЭУББТСТ	-
3.6.1.2	Зоонозын өвчний байгалийн голомтын эрсдлийн зураглалд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	1	Зоонозын өвчний эрсдлийн зэрэглэлийг тогтоох судалгаа хийх	Боом, галзуу өвчний эрсдлийн зэрэглэлийг тогтоох судалгаа хийх	Жилдээ	Судалгааны тайлан	ЭУББТСТ	-
		2	Зоонозын өвчний байгалийн голомтын эрсдлийг	Боом, галзуу өвчний байгалийн голомтын эрсдлийг	Жилдээ	Эрсдлийн зураг, өвчин тус бүрээр	ЭУББТСТ	-

			тогтоон, зураглал гарган шинэчлэх	тогтоон, зураглал гарган шинэчлэх				
		3	Зоонозын өвчний байгалийн голомтын хяналт-тандалтын нарийвчилсан төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлэх	Зоонозын өвчний байгалийн голомтын хяналт-тандалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	Жилдээ	Төлөвлөгөө	ЭУББТСТ	-
3.6.1.3	Зоонозын өвчний байгалийн голомтод мэрэгч, шимэгч, шавж устгалт хийхэд шаардагдах хөрөнгийг үе шаттай шийдвэрлэснээр уг үйл ажиллагааг тогтмолжуулах	1	Эрсдэлт бүс нутаг, хот суурин газарт мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл, шавжгүйтгэл хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Тарваган тахал өвчний байгалийн голомтын эпизоотийн идэвх, тархвар судлалын эрсдлийг бууруулах (мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл) ажлын зааврыг шинэчлэн боловсруулна.	II улиралд	Боловсруулсан зааврын тоо	ЭУББТСТ	-
		2	Дамжуулагчаар дамжих халдвараас сэргийлэх бэлдмэлийг сурталчлах, сэргийлэлтэд нэвтрүүлэх	Дамжуулагчаар дамжих халдвараас сэргийлэх бэлдмэлийг судлах, нэвтрүүлэх		Судалгааны тайлан	ЭУББТСТ	-
Үйл ажиллагааны чиглэл 2. Дамжуулагчаар дамжих халдвар болон зоонозын анзаарагддаггүй зарим өвчний тандалтыг өргөжүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
3.6.2.1	Дамжуулагчаар дамжих зоонозын зарим өвчнийг тогтмол тандах өвчний жагсаалтад оруулан тандалтыг жигдрүүлэх	1	Дамжуулагчаар дамждаг халдварт өвчнүүдийн хяналт, сэргийлэлтийн удирдамжийг боловсруулах /2017-2019/	Хачигт энцефалит, хачигт риккетсиоз, хачигт боррелиоз өвчний хяналт сэргийлэлтийн заавар"-ыг шинэчлэн боловсруулж батлуулан,	Жилдээ	Батлагдсан удирдамж	ЭУББТСТ ЛЛТ	-

				хэрэгжүүлж ажиллана.				
3.6.2.2.	Анзаарагддаггүй зоонозын өвчний тандалтын тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэх, оношилгооны чадавхийг сайжруулах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах	1	Анзаарагддаггүй зарим зоонозын өвчнүүдийн хяналт, сэргийлэлтийн удирдамжийг боловсруулах	Бэтэг өвчний хяналт сэргийлэлтийн заавар"-ыг инэчлэн боловсруулж батлуулан, хэрэгжүүлж ажиллана.	Жилдээ	Батлагдсан удирдамж	ЭУББТСТ ЛЛТ	-
Үйл ажиллагааны чиглэл 3. Зоонозын өвчний эрт сэрэмжлүүлэг, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
3.6.3.1.	Зоонозын өвчний тандалт, хяналтын тогтолцоог болон салбарын оролцоонд тулгуурлан зохион байгуулах	1	Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчний жагсаалтыг шинэчлэх	Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчний жагсаалтыг шинэчлэнэ.	Жилдээ	Батлагдсан тушаал	ЭУББТСТ	-
		2	Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Тарваган тахал, боом, листериоз, пастереллёз, хулгана тахал, хуурмаг сүрьеэ, ям, лептоспироз, хачигт борреллиоз, хачигт энцефалит, япон энцефалит, галзуу, баруун нилийн чичрэг, криптоспоридиоз өвчний оношилгоо, эмчилгээ, тандалтын стандартыг шинэчлэн боловсруулна.	Жилдээ	Батлагдсан стандарт, журам, заавар	ЭУББТСТ ЛЛТ	-

		3	Тарваган тахал, зэрэг нутагшмал өвчний эрсдлийн зэрэглэлийг тогтоох /2017-2020/	Тарваган тахал, боом, галзуу зэрэг нутагшмал өвчний эрсдлийн зэрэглэлийг тогтооно.	Жилдээ	Эрсдлийн зураглал	ЗӨСҮТ	ХХААХҮЯ ЭМЯ Аймаг, нийслэлийн ЗӨСТ
		4	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг шинэчлэх / 2017/	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж, удирдамжийг шинэчлэнэ.	Жилдээ	Батлагдсан тушаал	ЭМЯ ЗӨСҮТ ОБЕГ МХЕГ	ХХААХҮЯ
		5	Байгалийн голомт болон зоонозын шалтгаант үйл явдалд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийх	Байгалийн голомтын төлөв байдал, өвчлөлийн хандлагад эрсдлийн үнэлгээ хийнэ.	Жилдээ	Үнэлгээний дүн	ЭУББТСТ ШУН	-
		6	Судалгаа, шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоож, төсөл боловсруулан хэрэгжүүлэх	Тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Жилдээ	Судалгааны тайлан	НЭМЭШСА	-
3.6.3.2	Зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн зоонозын өвчний өвөрмөц болон өвөрмөц бус сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Зоонозын шалтгаант халдвараас сэргийлэх санамж, зурагт хуудасны эх боловсруулах, хэвлүүлэх, түгээх	Зоонозын өвчнөөс сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээнэ.	Жилдээ	Сурталчилгааны Материалын тоо	ЭУББТСА ЗТХНСА	НЭМЭШСА
		2	Зоонозын халдвараас Сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах /2017-2020/	Зоонозын халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилдээ	МСС-ны материалууд	ЭУББТСА ЗТХНСА	-

3.6.3.3	Зоонозын өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрсдлийн нөөцийн сан бүрдүүлэх	1	Дэгдэлтийн үеийн бэлэн байдлын нөөцийн жагсаалтыг шинэчлэх, нөхөн хангалт хийх /2017-2020/	Дэгдэлтийн үеийн бэлэн байдлын нөөцийн жагсаалтыг шинэчилж, нөхөн хангалт хийнэ.	Жилдээ	Батлагдсан тушаал	ЭУББТСА	-
		2	Орон нутгийн эмч нарыг сургах, дадлагажуулах /2017-2018/	Орон нутгийн ЗӨСТ-ийн эмч нарыг үндсэн мэргэшлийн болон ажлын байрны дагалдуулах сургалтад сургаж, дадлагажуулна.	II улиралд	Сургагдсан мэргэжилтний тоо	НЭМСЭША	-
		3	Зоонозын халдварын оношилгооны лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж, оношлуураар хангах /2017-2020/	Шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж, оношлуураар хангах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо	ЛЛТ	-
3.6.3.4	Үндэсний болон орон нутгийн зоонозын өвчин судлалын төвийн лабораторид биоаюулгүй байдал, био эрсдлийн менежментийг үе шаттайгаар нэвтрүүлэх	1	Биологийн эрсдэлтэй бичил биетний эрсдлийн үнэлгээ хийх, зэрэглэлийг шинэчлэн тогтоох /2017-2019/	Биологийн эрсдэлтэй бичил биетний эрсдлийн үнэлгээ хийх,		Үнэлгээний дүн	МТА	-
		2	Биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан гарын авлага, зөвлөмж боловсруулах, түгээх /2017-2019/	Биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан гарын авлага, зөвлөмж боловсруулах, түгээх		Гарын авлагын тоо	МТА	-

		3	Лабораторийн чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх	Лабораторийн MNS 15189 магадлан итгэмжлэлийн бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Гарын авлага Баталгаажуулсан сорьцын тоо	ЛЛТ	-
		4	Зоонозын зарим өвчний үүсгэгчийг орон нутагт тодорхойлох шинжилгээ хийх	Бруцёллез, криптоспиридиоз, хуурмаг сүрьеэ, хулгана тахал, өвчний үүсгэгчийг ялгах, дүйн тодорхойлох шинжилгээг хийх	Жилдээ	Шинжилгээний төрөл, тоо	ЛЛТ	Аймаг, нийслэлийн ЗӨСТ
		5	Лабораторийн эмч нарыг сургах, чадавхжуулах	Хачигт халдварын лабораторийн оношилгооны арга зүйн ажлын байрны сургалт зохион байгуулах	Жилдээ	Сургагдсан мэргэжилтний тоо	ЛЛТ	НЭМЭШС А
3.6.3.5	Зоонозын шалтгаант хүний өвчлөлийн тохиолдлыг эрт илрүүлэх, мэдээлэх, оношлох, эмчлэх, хянах, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	1	Зоонозын өвчний хүний өвчний тохиолдлын оношилгоо-эмчилгээ, тандалт хариу арга хэмжээг зохион байгуулах/ 2017-2020/	Зоонозын өвчний хүний өвчний тохиолдлын оношилгоо-эмчилгээ, тандалт хариу арга хэмжээг зохион байгуулна.	Жилдээ	Хариу арга хэмжээ Хэрэгжүүлсэн хүний өвчний тохиолдлын тоо	ЭУББТСТЛЛТ	-
		2	Зоонозын шалтгаант үйл явдалд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийх /2017-2020/	Зоонозын өвчний дэгдэлт, үйл явдал бүртгэгдсэн тохиолдолд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, хариу арга хэмжээний зөвлөмж боловсруулан хүргүүлнэ.	Жилдээ	Эрсдлийн үнэлгээний тайлан	ЭУББТСТ ШУН	-

		3	Үүсгэгчийн молекул-эпидемиологийн судалгааг хийх /2017-2019/	Үүсгэгчийн молекул-эпидемиологийн судалгааг хийх удирдамжийг боловсруулах	Жилдээ	Судалгааны тайлан	ЛЛТ	-
		4	Зоонозын өвчний лабораторийн оношилгоог баталгаажуулах /2017-2020/	Зоонозын өвчний тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр оношийг баталгаажуулах		Батлагдсан тохиолдлын тоо	ЛЛТ	-

Төлөвлөгөө нэгтгэсэн: Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Handwritten signature

Н. Ураншагай

Хянасан:

Захиргаа, төлөвлөлт, хүний нөөц, статистикийн албаны дарга

Handwritten signature

Б. Батжаргал

Мэргэжлийн тусламжийн албаны дарга

Handwritten signature

Д. Ганболд

Чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын албаны дарга

Handwritten signature

Э. Тунгалаг

Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга

Handwritten signature

Д. Алтантогтох

Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний албаны дарга

Handwritten signature

З. Ууганцэцэг